Дүн	4,361,526.9	4,863,913.7	502,386.8	100.0

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.7. Орлогын данс

Шинэжинст сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 88 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 561,475.9 мянга, татварын бус орлогыг 8,000.0 мянга, нийт 569,475.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 11. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

№	Нийт орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Сумын төсвийн татварын орлого	561,475.9	844,839.1	-283,363.2	150.5
1	цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	133,200.0	236,662.6	-103,462.6	177.7
2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,600.0	4,234.6	365.4	92.1
3	Газрын төлбөр	236,875.9	297,050.8	-60,174.9	125.4
4	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	19,000.0	24,887.0	-5,887.0	131.0
5	Галт зэвсгийн албан татвар	1,650.0	1,650.0	0.0	100.0
6	Улсын тэмдэгтийн хураамж	5,700.0	795.8	4,904.2	14.0
7	Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,000.0	6,720.0	-3,720.0	224.0
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	17,900.0	164,042.2	-146,142.2	916.4
9	Хадгаламжийн хүүгийн орлого	30,600.0	32,376.9	-1,776.9	105.8
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	17,878.0	3,500.0	14,378.0	19.6
11	Малын тоо толгойн албан татвар	80,000.0	72,454.9	7,545.1	90.6
12	Ан амьтан агнуурын нөөц ашигласны төлбөр	7,072.0	0	7,072.0	0.0
13	Ус ашигласны төлбөр	1,000.0	255.5	744.5	25.6
14	Газрын дуудлага худалдаа	3,000.0	208.8	2,791.2	7.0
	Сумын төсвийн татварын бус орлого	8,000.0	21,365.0	-13,365.0	267.1

15	Торгуулийн орлого	8,000.0	21,365.0	-13,365.0	267.1
	Нийт орлогын дүн	569,475.9	866,204.1	-296,728.2	152.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 150.5 хувь буюу 283,363.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл галт зэвсгийн албан татварыг орлогыг бүрэн биелүүлсэн, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 103,462.6 мянга, газрын төлбөр 60,174.9 мянга, ИОТХ 5,887.0 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 3,720.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 146,142.2 мянга, хадгаламжийн хүүгийн орлогыг 1,776.9 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Тус суманд “Эрдэнэ монгол” ХХК нь сайжруулсан зам тавьж бүтээн байгуулалтын ажил хийсэнтэй холбоотойгоор түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр огцом өссөн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татвар 365.4 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,904.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 14,378.0 мянга, малын тоо толгойн албан татвар 7,545.1 мянга, ан амьтан агнуурын нөөц ашигласны төлбөр 7,072.0 мянга, ус ашигласны төлбөр 744.5 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,791.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Хүү торгуулийн орлого 267.1 хувь буюу 13,365.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 88 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 2,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр түрээсийн орлогоор 792.4 мянган төгрөгийн орлогыг оруулжээ.

Дээрх тогтоолоор хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 63,423.2 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 115,068.7 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 181.4 хувиар биелүүлсэн нь зориулалт бус зээлийн эргэн төлүүлсэнтэй холбоотойгоор биелэлт өссөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн харилцах дансанд 53,998.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 155,965.6 мянган төгрөгийн авлагатай байна.

ОНХС-ийн орлогоор 65,230.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 39,798.0 мянган мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 61.0 хувийн биелэлтэй байгаа нь өвс тэжээлийн тендерийг хожуу зарласнаас өвс тэжээлийг борлуулаагүй үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Мөн тогтоолоор “Эрдэнэ монгол” ХХК-иас 300,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал төлөвлөснөөс 300,000.0 мянган төгрөг орсон байна.

3.4.8. Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,823,379.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,659,928.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,142,870.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,517,057.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт 12. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөрөөр

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,823,379.5	2,659,928.1	163,451.4	94.2
2	70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	96,970.9	96,566.9	40.0	99.6
3	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	96,970.9	96,566.9	40.9	99.6
4	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	779,812.2	736,088.6	43,723.6	94.4
5	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	551,467.8	544,515.1	6,952.7	98.7

6	80106 Баг, хорооны ҮАЗардал	74,948.7	73,664.2	1,284.5	98.3
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	35,767.1	35,458.1	309.0	99.1
8	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	29,691.0	16,922.9	12,768.2	57.0
9	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	62,800.0	42,879.4	19,920.6	68.3
10	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	25,137.6	22,649.0	2,488.6	90.1
11	70503 Орон нутгийн зорилтот ХОруулалалт	1,620,255.0	1,517,057.8	103,197.2	93.6
12	80904 Нийгмийн зориулалттай барилга	803,968.6	774,820.4	29,148.2	96.4
13	83401 Итгэлцүүрээр олгох	492,310.0	473,461.0	18,849.0	96.2
14	83402 Хайгуулын тусгай зөвшөөрөл	34,210.5	34,210.5	-	100.0
15	83403 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	138,587.2	138,587.2	-	100.0
16	83405 Малын тоо толгойн албан татвар	80,000.0	24,800.0	55,200.0	31.0
17	83406 Бусад	71,178.7	71,178.7	-	100.0
18	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	35,728.4	28,162.9	7,565.5	78.8
19	80112 ТЗШ- байгууллагуудын тогтмол зардал	35,728.4	28,162.9	7,565.5	78.8
20	71702 Соёл урлаг	36,342.8	34,880.7	1,462.1	96.0
21	80112 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	36,342.8	34,880.7	1,462.1	96.0
22	71801 Сургуулийн өмнөх боловсрол	29,512.2	25,779.6	3,732.6	87.4
23	80112 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	29,512.2	25,779.6	3,732.6	87.4
24	71802 Ерөнхий боловсрол	124,235.9	122,127.4	2,108.5	98.3
25	80112 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	124,235.9	122,127.4	2,108.5	98.3
26	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	100,522.1	99,264.1	1,258.0	98.7
28	82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	100,522.1	99,264.1	1,258.0	98.7

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн гүйцэтгэлийн тайлан"

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1. Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 4 төсвийн байгууллага, улсын төсвийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Шинэжинст сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 77 дугаар тогтоолоор нийт 2,311,109.2 мянган төгрөгийг анх баталсан байна.

Хүснэгт 13. Байгууллагуудын төсвийн төсөл, батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Тодотгон баталсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	75,640.0	82,320.9	96,970.9	-21,330.90
Засаг даргын Тамгын газар	642,292.0	589,091.9	779,812.2	-137,520.20
Сургууль	120,835.9	120,835.9	124,235.2	-3,399.30

Цэцэрлэг	27,712.2	27,712.2	29,512.2	-1,800.00
Эрүүл мэндийн төв	34,528.4	34,528.4	35,728.4	-1,200.00
Соёлын төв	35,842.8	35,842.8	36,372.8	-530.00
Хоршоо хөгжүүлэх сан	95,642.8	100,522.1	100,522.1	-4,879.30
Орон нутгийн хөгжлийн сан	758,962.9	1,320,255.0	1,620,255.0	-861,292.10
Нийт дүн	1,716,573.4	2,311,109.2	2,823,379.5	-1,106,806.10

Эх сурвалж: Шинэжинст сумын ИТХ-ын тогтоол

Шинэжинст сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 88 дугаар тогтоолоор төсвийг 475,171.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгон 2,823,379.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2. Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 77 дугаар тогтоолоор анх баталсан 2,311,109.2 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 88 дугаар тогтоолоор төсвийг 475,171.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,823,379.5 мянган төгрөгийн төсөв баталсан.

Нийт зардлын 569,475.9 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 611,126.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 736,286.4 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 2,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 475,837.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 63,423.2 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 65,230.0 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрөх өвс тэжээлийн орлогоос, 300,000.0 мянган төгрөгийг уул уурхайн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, ОНХС-ийн шилжүүлгийг 18,849.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 51,645.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 57,788.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 14. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	779,812.2	736,088.6	43,723.6	94.4	42,516.0
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	96,970.9	96,567.0	403.9	99.6	403.9
Ерөнхий боловсролын сургууль	124,235.9	122,127.4	2,108.5	98.3	2,108.5
Цэцэрлэг	29,512.2	25,779.6	3,732.6	87.4	3,732.6
Эрүүл мэндийн төв	35,728.4	28,162.9	7,565.5	78.8	7,565.5
Соёлын төв	36,342.8	34,880.7	1,462.1	96.0	1,462.1
Орон нутгийн хөгжлийн сан	1,620,255.0	1,517,057.8	103,197.2	93.6	
Хоршоо хөгжүүлэх сан	100,522.1	99,264.1	1,258.0	98.7	
Нийт дүн	2,823,379.5	2,659,928.1	163,451.4	94.2	57,788.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,659,928.1 мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажлын санхүүжилтийг өгөөгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3. Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 19,496.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт өгснөөс бараа үйлчилгээний зардалд 8,518.3 мянган төгрөг зарцуулж 10,977.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО			19,496.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,661.0	1,300.0	17,961.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,535.0	0	1,535.0
НИЙТ ЗАРЛАГА			19,496.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	7,718.3	800.0	8,518.3
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,477.7	500.0	10,977.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

5.4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх албан бичгийг 2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 288 дугаар албан бичгээр ирүүлж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

Сумын Засаг даргаар Б.Бат-Эрдэнэ, санхүү албаны даргаар Х.Дагважав ажилласан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2023 оны батлагдсан төсөв 2,823,379.5 мянган төгрөгийн 1.5 хувь буюу 28,233.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,763.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Баянлиг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс хугацаанд нь 153 мэдээллийг, хугацаа хоцроож 24 мэдээллийг мэдээлж, 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

Хүснэгт 16. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	8	2	2
2	Хагас жил	3	3	3	-	-
3	Улирал бүр	2	8	8	-	-
4	Сар бүр	5	60	55	5	-
5	Тухай бүр	6	72	55	17	-
	Нийт	29	155	129	24	2

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 9,303.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 134 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 17. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	0.0	3	0.0	-	-	100
Албан шаардлага	1	9,303.0	1	9,303.0	-	-	100
Нийт	4	9,303.0	4	9,303.0	-	-	100

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4.7 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Шинэжинст сумын Засаг даргын харьяа 1 байгууллагад дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Зөрчилгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1	1	0	1		1			
ИТХурал	1	1			1	1				
ОНХС	1	1			1	1				
ХХС	1	1			1	1				
НИЙТ ДҮН	4	4	1	3	4	0	1	0	0	0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 330,096.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 137,456.0 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 183,340.3 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 9,300.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №19. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил										
ИТХурал	2	9,045.3	2	9,045.3	-	-	-	-	-	-
ЗДТГ	10	132,936.6	4	17,127.9	-	-	5	106,508.7	1	9,300.0
ОНХСан	2	50,000.0	2	50,000.0	-	-	-	-	-	-
ХХС	2	61,282.8	2	61,282.8	-	-	-	-	-	-
СТА алдаа, зөрчлийн дүн	16	253,264.7	10	137,456.0	-	-	5	106,508.7	1	9,300.0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ИТХурал	1	8,031.6	-	-	-	-	1	8,031.6	-	-
ОНХСан	1	68,800.0	-	-	-	-	1	68,800.0	-	-
Нийцлийн аудитын дүн	2	76,831.6	-	-	-	-	2	76,831.6	-	-
НИЙТ ДҮН	18	330,096.3	10	137,456.0	-	-	7	183,340.3	1	9,300.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 253,264.7 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 76,831.6 мянган төгрөгийн 2 зөрчил тус тус илэрсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,800.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 37,800.4 мянган төгрөгийн зөрлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

5.1.1. Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 150.5 хувь буюу 283,363.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 365.4 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,904.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 14,378.0 мянга, малын тоо толгойн албан татвар 7,545.1 мянга, ан амьтан агнуурын нөөц ашигласны төлбөр 7,072.0 мянга, ус ашигласны төлбөр 744.5 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,791.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.3 дахь “энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж”, 23.8.4 дэх “агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж”, 23.8.9 дэх “хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр”, 23.8.12 дахь “хог хаягдлын үйлчилгээний хураамж”, 23.8.14 дэх “газрын төлбөр”, 23.8.15 дахь “малын тоо толгойн албан татвар”, 23.8.16 дахь “энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Сумын төсөвт төвлөрөх албан татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод, хяналт хариуцлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар нийт 330,096.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 137,456.0 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 183,340.3 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 9,300.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийг мөрдөж Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад тавих хяналт, төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 150.5 хувь буюу 283,363.2 мянган төгрөгөөр	1	37,800.4	-	-	1	37,800.4	-	-

давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 365.4 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,904.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 14,378.0 мянга, малын тоо толгойн албан татвар 7,545.1 мянга, ан амьтан агнуурын нөөц ашигласны төлбөр 7,072.0 мянга, ус ашигласны төлбөр 744.5 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,791.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.								
Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар нийт 330,096.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 137,456.0 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 183,340.3 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 9,300.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.	1	0	-	-	-	-	1	-
Дүн	2	37,800.4	-	-	1	37,800.4	1	-

Хавсралт 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Хүснэгт №20. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Огноо 2024	Аудитын нэр:	Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2024/17/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Шинэжинст сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		330,096.3			
Засаг даргын тамгын газар		132,936.6			
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл					
1	Үндсэн хөрөнгөд 2021 онд бүртгэсэн 53,900 мянган төгрөгийн 2 худаг, 2023.10.04-ний өдөр бүртгэсэн 12,519.0 мянган төгрөгийн кантинар сэргээгдэх эрчим хүчийг -1 жилээр бүртгэсэн байна.	5,702.9	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
2	Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс байршуулсан 1,445.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байна.	1,445.0	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
3	Шинэжинст сумын Засаг дарга ГЗБГЗЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгавар"-ыг баталж, 20,000.0 мянган төгрөгийг Шинэжинст сумын ЗДТГ-аас шилжүүлэхээр заасан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 9,900.0 мянган төгрөг шилжүүлэн ажлыг бүрэн хийж дуусаагүй байхад тайлант жилийн зардлаар тайлагнасан байна.	9,900.0	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
4	Сумын ОНХС-аас тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд олгосон урамшууллыг сумын ЗДТГ-аар дамжуулан олгосон бөгөөд нэг гишүүний урамшууллыг тайлант жилийн орлогоор бүртгэсэн байна.	80.0	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
Дүн		17,127.9			

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл					
1	Байгууллагын санхүүгийн тайланд 2019 онд бүртгэсэн 12,360.0 мянган төгрөгийн 206 тоо толгой ухна ишиг, 37,256.0 мянган төгрөгийн 519 толгой мал амьтан бүртгэлтэй байгаа нь малын А дансаар баталгаажуулж, завсрын аудитаар мал амьтан байхгүй гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлсэн атлаа оны эцэст хийсэн тооллогоор байгаагаар тоолж, тооллогын комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.	49,616.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
2	Бусад нөөц дансанд 2018-2022 онд бэлтгэсэн 5 төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн 46,500.0 мянган төгрөгийг бүртгэж, үүнээс 3 төсөл арга хэмжээний тендер зарлаж, хэрэгжсэн байхад зураг төсвийн үнийг суутган тооцож аваагүй байна.	46,500.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
3	Шинэжинст сумын ЗДТГ-т эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон 8 нэр бүхий газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд 636 м2, 1504 м2 талбай бүхий газрыг илүү бүртгэсэн байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
4	Хог хаягдлын хураамжийн зардалд тухайн жилд 25,137.0 мянган төгрөг баталж, хог хаягдлын гэрээг иргэнтэй байгуулж ажиллан, эхний 10 сарын байдлаар төсвөөс 12,800.0 мянган төгрөгийг олгосон байхад хог хаягдлын хураамжийн орлогоор 3,500.0 мянган төгрөгийг оруулсан байна.	9,300.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
5	Тусгай зориулалтын материал, бусад материалын тайланг гаргаж ирүүлээгүй, нярвын бэлтгэсэн бараа материалын тайлангийн сарын орлого, зарлагын дүн ерөнхий дэвтэр дэх дүнгээс зөрүүтэй байна.	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Батхуяг, Х.Доржсамбуу
	Дүн	115,808.7			
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		17,076.9			
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл					
1	Сумын ИТХ-ын НДШ-ийн өглөгийг 12,9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, мөн цалингийн урьдчилгаа 15,950.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний журналд цалингийн өглөгөөр 413101 дансаар бүртгэснийг 34713 дансаар залруулж бүртгэх	0	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Т.Цэнгэлмаа, Х.Доржсамбуу
	Сумын ИТХ нь 2023.12.16-ны байдлаар цалингийн тооцоололтой холбоотой ХХОАТ-ын 2,349.5 мянга, үйлдвэрчний эвлэлийн 198,1 мянга, НДХ-т 6,497.8 мянга нийт 9,045.3 мянган төгрөгийн өртэй байна	9,045.3	Залруулга хийх	Дарга, нягтлан бодогч	Т.Цэнгэлмаа, Х.Доржсамбуу
	Дүн	9,045.3			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
2	Шилэн дансны системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлэхдээ нийт 8,031.6 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	8,031.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Т.Цэнгэлмаа, Х.Доржсамбуу
	Дүн	8,031.6			
Орон нутгийн хөгжлийн сан		118,800.0			
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл					
1	Аймгийн Засаг даргын 2023.09.05-ны өдрийн А/472 тоот захирамжаар ЭМТ-ийн барилгын их засварын ажлын санхүүжилт 50,000,000 төгрөгийг аймгийн ОНХС-аас санхүүжүүлэхийг АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаад даалгасны байсан боловч 2023.11.06-ны өдөр Шинэжинст сумын ОНХС-ийн данснаас 50,000,000 төгрөгийн зарлага гарсан байна. Энэ нь ОНХС-ын журмын 4 дүгээр зүйлийн 4.6 "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.	50,000.0	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ, С.Хишигтогтох
2	Шинэжинст сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн "Халдваргүйжүүлэлтийн ДУК машин авах" ажлыг 2023 оны 06 сард, "Соёлын төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах" ажлыг 2023 оны 05 сард тус тус хүлээн авсан боловч сумын ИТХ-аар хэлэлцүүлж орлого аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг зөрчсөн байна.	0	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ, С.Хишигтогтох



Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	Дүн	50,000.0			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Шилэн дансны системд тендерийн 68,800,000.00 (Жаран найман сая найман зуун мянган) төгрөгийн 1 мэдээ мэдээлээгүй байна.	68,800.0	Албан шаардлага	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ, С.Хишигтогтох
	Дүн	68,800.0			
Хоршоо хөгжүүлэх сан		61,282.8			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Хоршоо хөгжүүлэх сангийн 2023.01.01-ний үлдэгдэл 16,837,562 төгрөгийн 8 зээлдэгчийн үлдэгдэлтэй байсан ба зээлдэгч нарын хувийн хэрэгтэй тулгалт хийхэд санхүүгийн тайланд авлагыг бүртгэхдээ 7 зээлдэгчийн 57,595,752 төгрөгийн авлагыг илүү, 1 зээлдэгчийн 50,000,000 төгрөгийн авлагыг дутуу тусгасан байна.	57,595.8	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ, С.Хишигтогтох
2	ХАА-н Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчийн дэлгэрэнгүй программд байгаа зээлийн үлдэгдэл 162,599,036 төгрөг байгаа ба санхүүгийн тайлангийн авлагатай тулгалт хийхэд 619,790 төгрөгийн хүүгийн авлагыг илүү бүртгэсэн, мөн Залаа шинэ эргэлт хоршоо зээлээ урьдчилан төлсөн байхад дээрх программд 3,067,269 төгрөгийн хүүгийн үлдэгдэлтэй байна.	3,687.0	Залруулга хийх	Засаг дарга, нягтлан бодогч	Б.Бат-Эрдэнэ, С.Хишигтогтох
	Дүн	61,282.8			

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 270/А0571/21
БНА-2024/17/НА-СТА-773

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 150.5 хувь буюу 283,363.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 365.4 мянга, улсын тэмдэгтийн хураамж 4,904.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 14,378.0 мянга, малын тоо толгойн албан татвар 7,545.1 мянга, ан амьтан агнуурын нөөц ашигласны төлбөр 7,072.0 мянга, ус ашигласны төлбөр 744.5 мянга, газрын дуудлага худалдааны орлого 2,791.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.3 дахь “энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж”, 23.8.4 дэх “агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж”, 23.8.9 дэх “хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр”, 23.8.12 дахь “хог хаягдлын үйлчилгээний хураамж”, 23.8.14 дэх “газрын төлбөр”, 23.8.15 дахь “малын тоо толгойн албан татвар”, 23.8.16 дахь “энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан


5040820

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэжинст сумын Засаг дарга Б.Бат-Эрдэнэ, Санхүү албаны дарга Х.Дагважав нарт даалгав .

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН¹:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ

¹ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно